

ШИВЭЭГОВЬ СУМЫН 2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

2024.08.30

Шивээговь сум

НЭГ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Сумын Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулж, сумын Засаг даргаас 3 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Сумын Засаг даргын Зөвлөлийн хурлыг 08 дугаар сард зохион байгуулаагүй байна.

“Шивээговь сум мэдээ” цахим хаягаар нийт-23 мэдээллийг нийтлэн, бусад байгууллагын 11 мэдээллийг шэйрлэн, шинээр-12 мэдээ мэдээллийг иргэдэд хүргэн ажилласан. 2024 оны 07 дугаар сарын 22-ны байдлаар сумын цахим хуудасны нийт дагагчийн тоон үзүүлэлт- 4464 болсон байна. Сумын хэмжээнд болж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг тогтмол оруулан, бусад зар мэдээллийн 8 группэд дамжуулан иргэдэд хүргэн ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлт болон халамжийн үйлчилгээг нийт 34 иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 10 иргэнд, халамжийн 11 төрлийн үйлчилгээг 24 иргэнд тус тус хүргэсэн байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн 4 төрлийн төсөл арга хэмжээний төсөл болон Нийгмийн халамжийн хэлтсийн Олон нийтийн оролцооны бүлгийн төсөл хүлээн авч байна. Нийтийг хамарсан ажлын 03 дугаар ээлж хуваарийн дагуу ажиллаж байна.

ХОЁР. ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг “Бэлчээрийн газрын өөрчлөлтөд фото мониторинг хийх аргачлал”-ын дагуу сумын Засаг даргын 2024 оны 08 сарын 07-ний өдрийн А/109 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан, сумын 3-н бэлчээр ашиглалтын хэсэг болох Сэвхүүлийн говь, Эрдэнэтөлгой, Зүүн хангайн бэлчээр ашиглалтын өвөлжөө, хаваржаа, намаржаа, зунжааны газарт нийт 9 цэгээс 2024.08.10-ний өдөр дээж авч, тандан судалгаа хийж ажилласан.

Тус хээрийн судалгааны ажлыг үндэслэн 9 цэгийн ургамлын мэдээллийг Sample Point программ дээр боловсруулан, Газрын кадастрын мэдээллийн сангийн программд орчны болон бүрхэцийн зураг, ургацын мэдээлэл, малын тоо толгой, био массын мэдээлэл зэргийг бүрэн оруулан суурин боловсруулалтын ажлыг хийн ажилласан байна.

Мөн сумын Засаг даргын 2024 оны 08 сарын 22-ны өдрийн А/112 тоот захирамжаар сумын хэмжээнд байгаа геодезийн цэг тэмдэгтийн тооллогын ажлыг хийж гүйцэтгэхээр 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан, сумын “Геодезийн цэг тэмдэгтийг тоолох ажил”-ыг 2024 оны 08 сарын 27-ний өдөр хийж гүйцэтгэлээ.

Сумын Сонгуулийн хороо, Хэсгийн хороодууд холбогдох хууль дүрэм журмыг мөрдлөг болгон, хуульд заасан хугацааны дагуу ажил чиг үүргээ гүйцэтгэн ажилласан байна.

ГУРАВ. ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВ САНХҮҮГИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн 6н байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 2024 оны 08 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 100 хувьтай, байршуулвал зохих 420 мэдээллийг ил тод мэдээллэсэн байна.

ДӨРӨВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

2024 оны 07 дугаар сарын 31-ний өдөр аймгийн Мал эмнэлгийн газрын байцаагч, сумын ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн болон бусад холбогдох мэргэжлийн албан хаагчид суманд малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн худалдан борлуулдаг ААН, худалдааны цэгүүдээр хяналт шалгалтыг хийлээ. Тус явцын шалгалтын дагуу тухайн ААН-үүдэд албан шаардлага өгч, малын махнаас сорьц дээжийг авч, шинжилгээнд явуулаад байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сумын “Илчлэг Шивээ” ААТҮГ нь халаалтын зуухны засвар үйлчилгээний ажлыг хийж байна. Үүнд: халаалтын 1, 2, 3, 4 дүгээр зуухны урсгал засвар, цэвэрлэгээг хийж, зуухнуудын хэвийн ажиллагаанд бэлтгээд байна.

ТАВ. ДЭД БҮТЭЦ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

1. - **Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар** батлагдсан 2 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан. Үүнд:

- ✓ Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажил /08.09/
- ✓ Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах ажил
- ✓ Ёслол хүндэтгэлийн өргөө гэр авах ажлуудын тендерийг /08.09/ зарлаад байна.

Шивээговь сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй Сургуулийн спорт заалны их засварын ажил 100 хувийн гүйцэтгэлтэйгээр бүрэн дууссан бөгөөд ажлыг хүлээн авах комиссыг сумын Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/102 дугаар захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тус ажлыг 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр хүлээж аваад байна.

Ус хангамжийн нэмэлт их үүсвэр, шугам сүлжээний автоматжуулалтын ажил 100 хувийн гүйцэтгэлтэйгээр бүрэн дууссан бөгөөд ажлыг хүлээн авах комиссыг сумын Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/103 дугаар захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тус ажлыг 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр хүлээж аваад байна.

Мөн сумын Нэрт багийн нутаг дэвсгэрт Нийтийн биеийн тамирын талбай/хөл бөмбөгийн талбай/ байгуулах ажил 100 хувийн гүйцэтгэлтэйгээр бүрэн дууссан бөгөөд ажлыг хүлээн авах комиссыг сумын Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тус ажлыг 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр хүлээж аваад байна.

Шивээговь сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй Хуучин хог хаягдлыг булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажил, Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг дэмжих /байр засварлах/ зэрэг ажлууд үргэлжлэн хийгдэж, 70-90%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасныг үндэслэн худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгон зарласан байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан-3

ЗУРГАА. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Боловсролын чиглэлээр: Сумын Ерөнхий боловсролын сургууль, 3 дугаар цэцэрлэг нь хичээл сургууль эхлэх болсонтой холбоотойгоор засвар үйлчилгээний ажлуудыг хийгээд байна. Үүнд:

- Сургуулийн кабинет болон сургуулийн урлаг заал, анги танхимын нийт 14 паарыг сольж, янзлах
- Урлаг заалны шал, хана, номын сангийн уншлагын танхимын ханыг будаж хулдааслах
- Дотуур байрны тасгуудын хананд обой нааж, угааж цэвэрлэн, дотуур байрны кридорын хана, хаалганы эвдэрхий, халзарсан будгийг хусаж янзалж өнгийг сэргээх
- EduTen танхимд засвар үйлчилгээ хийж, халаалт тавих
- Цэцэрлэгийн шинэ барилгын дотоод засал, цэвэрлэгээ үйлчилгээ зэргийг хийх, тохижуулах зэрэг ажлуудыг хийж бэлтгээд байна.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

“Хог хаягдлын менежмент” арга хэмжээний хүрээнд төсвийн байгууллагууд, ААН-үүд 14 хоног тутам өөрийн эзэмшлийн 50м хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэж байна. Мөн хог хаягдлын хураамж тогтоохтой холбоотой иргэдээс авах саналыг цахимаар болон цаасаар боловсруулж сумын олон нийтийн сүлжээнд байршуулсан. Эхний байдлаар цахимаар 41, цаасаар 35 санал аваад байна.

2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоотойгоор нийтийн эзэмшлийн зам, талбай, хүрээлэн буй орчинд нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулан ажиллалаа. Тус цэвэрлэгээнд 6 албан байгууллага, 15 ААН, иргэд зэрэг нийт 110 гаруй хүн оролцсон байна. Сумын ЗДТГ-аас хог хаягдал ачиж, зөөх ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 4.8 га талбайн 8 тонн хог хаягдлыг тээвэрлэн төв хогийн цэгт төвлөрүүлээд байна. Мөн ААН, албан байгууллагууд 7 хоног бүр хариуцсан эдэлбэр газрынхаа 50м хүртэлх талбайн хог хаягдлыг цэвэрлэж байна.

МЭДЭЭГ БЭЛТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН

МЭРГЭЖИЛТЭН

М.ГАНТУЯА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ